

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2012 оны 8 дугаар сарын 01

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2012 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна.

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2012-05 сар	/тоогоор/		2012-06 сар
			Нэмэгдсэн	Хасагдсан	
1	Даатгалын компани	18			18
2	Даатгалын компанийн салбар	190	1 ¹		191
3	Даатгалын төлөөлөгч	2159	23 ²	2 ³	2180
4	Даатгалын зуучлагч	12	1 ⁴		13
5	Даатгалын хохирол үнэлэгч	9			9
6	Актуарч	15			15
7	Бусад	15			15

Тайлант үед даатгалын компани, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны 2012 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 137 дугаар тушаалаар “Монре даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт даатгалын салбарын нээн ажилуулах тусгай зөвшөөрөл олгосон байна.

²Хорооны 2012 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-ийн 18 иргэнд, Хорооны 2012 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 138 дугаар тушаалаар “Монре даатгал” ХХК-д 5 иргэнд тус тус даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон байна.

³Хорооны 2012 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 139 дүгээр тушаалаар “Гэр даатгал” ХХК-ийн 1 иргэн, “Тэнгэр даатгал” ХХК-ийн 1 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

⁴ Хорооны 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 166 дугаар тогтоолоор “Изи инвестмент” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгов.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:


Даатгалын байгууллагуудын 2012 оны 06 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг тайлант үеийн өссөн дүнтэй харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :


№	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2012-06-30 Сарын дүн	2012-06-30 /өссөн дүн/
	Даатгалын нийт хураамж	9,366,174.20	41,705,837.20
	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан	2,423,258.80	8,261,606.90

журмын даатгал		
Олгосон нөхөн төлбөр	1,353,758.60	6,757,923.10
Үүнээс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	313,357.30	770,250.10
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	751.00	1,795.00
Давхар даатгалд төлсөн хураамж	1,810,709.00	9,761,722.50
Байгуулсан даатгалын гэрээний тоо	62,093.00	231,888.00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	52,089.00	168,510.00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	53,526.00	193,998.00
Хамгийн өндөр даатгалын үнэлгээтэй гэрээ		.00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	14,355,515.80	289,088.20

2012 оны 06 дугаар сарын байдлаар даатгалын хураамжийн орлого 2011 оны мөн үеийнхээс 3216.0 сая төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна. Жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого өмнөх сараас 1.07 дахин өсч, оны эхний 6 сарын байдлаар нийт 6757.9 сая төгрөг болсон байна.




2012 оны 06 дугаар сарын байдлаар даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 697.4 сая төгрөгөөр буюу 2.0 дахин өссөн. Жолоочийн албан журмын даатгалын нөхөн төлбөр өмнөх сараас 1.7 дахин өсөж, өссөн дүнгээр 770.2 сая төгрөгт хүрсэн байна.




2012 оны 06 дугаар сард “Жонон даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

Үзүүлэлт	6-р сар	/Төгрөгөөр/ Нийт дүн
Даатгалын нийт хураамж	119,311,626.34	359,911,808
Олгосон нийт нөхөн төлбөр	4,210,125.00	61,867,814
Давхар даатгалд төлсөн хураамж	1,288,089.55	24,713,906
Байгуулсан даатгалын гэрээний тоо	24.00	105
Хувь хүний хугацаат даатгалд	8.00	27
Байгууллагын хугацаат даатгалд	1.00	16
Өндөр хамгаалалттай ЭМД-д	0.00	0
Эмнэлгийн мөнгөний даатгалд	4.00	22
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	6.00	22
Тэтгэврийн даатгалд	1.00	10
Орон сууцны даатгалд	2.00	4
Хуримтлалын даатгалд	2.00	4
Зээлдэгчийн амь насны даатгалд	0.00	0
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн		
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	100,000,000.00	



Урт хугацааны даатгагчийн даатгалын хураамжийн орлого 2012 оны 06 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 92.2 сая төгрөгөөр буюу 4.4 дахин өссөн байна.



2012 оны 06 дугаар сарын байдлаар урт хугацааны даатгалын нөхөн төлбөр 2011 оны мөн үеэс 9.1 сая төгрөгөөр буурсан буюу 3.1 дахин багассан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	6-р сар	Нийт дүн
Даатгуулагчаас шууд орж ирсэн дүн даатгалын хураамж	41,574,337.74	376,874,069.57
Даатгалын зуучлагчийн орлого	20,525,347.32	204,802,482.01
Зуучилсан даатгалын гэрээний тоо	1526	3,767.00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	620,000,000.00	6,683,350,000

2012 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 41.6 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого олсон ба өмнөх оны мөн үеийнхээс 1.9 сая төгрөгөөр буюу 1.04 дахин өссөн байна.

Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр дүнтэй буюу 620.0 сая төгрөгийн үнэлгээтэй 24.6 сая төгрөгийн хураамж бүхий даатгалын гэрээг “Ачит ундарга” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Монголиан интернэшнл брокерс” ХХК нь 06 дугаар сарын мэдээ ирүүлээгүй болно.

“Аме” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Юу ай би” ХХК, “Гэрэлт буян ундрах” ХХК, “Си эн эн икс” ХХК-иуд үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	6-р сар	Нийт дүн
Даатгалын хохирол үнэлсэний орлого	12,514,927.00	51,124,291
Үнэлсэн даатгалын хохиролын тоо	716.00	2,792
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	11,511,000.00	292,497,281

2012 оны 06 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 12.5 сая төгрөгийн орлоготой ажиллаж, өмнөх оны мөн үеэс 9.1 сая төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК, “Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК-иуд үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

БУСАД

Хорооны 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 168 дугаар тогтоолоор “Хорооны 2009 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх заавар”-ыг хүчингүй болгож “Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан.

Хорооны 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 163 дугаар тогтоолоор “Мандал генерал даатгал” ХХК-д, 167 дугаар тогтоолоор “Мөнх даатгал” ХХК-д, 169 дүгээр тогтоолоор “Номин даатгал” ХХК-иудад тус тус дүрмийн сангийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС